

САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ 2021 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАНД ШИНЖИЛГЭЭ ХИЙСЭН ТАЛААРХ ТАНИЛЦУУЛГА

2022 оны 04 дүгээр
сарын 11-ний өдөр

Улаанбаатар
хот

ҮНДЭСЛЭЛ

Улсын Их Хурлын Хяналт шалгалтын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1.9 дэх заалт, Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 112 дугаар зүйлийн 112.2.10 дахь заалт, Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1 дэх хэсэгт заасны дагуу Санхүүгийн зохицуулах хороо болон Санхүүгийн зохицуулах хорооны дэргэдэх хяналтын зөвлөлөөс дараах тайланг ирүүлсэн. Үүнд:

- Санхүүгийн зохицуулах хорооны 2021 оны үйл ажиллагааны тайлангаа 2022 оны 03 дугаар сарын 28-ны өдрийн 1/1164 дүгээр албан бичгээр Эдийн засгийн байнгын хороонд;
- Санхүүгийн зохицуулах хорооны дэргэдэх хяналтын зөвлөлийн 2021 оны үйл ажиллагааны тайлангаа 2022 оны 03 дугаар сарын 30-ны өдрийн 08 дугаар албан бичгээр Эдийн засгийн байнгын хороонд;
- Банкны үйл ажиллагаанаас бусад санхүүгийн зах зээлийн зохицуулалт, хяналтад хамаарах чиглэлээр Монгол Улсын урт, дунд, богино хугацааны бодлогын баримт бичигт тусгагдсан зорилт, арга хэмжээний хэрэгжилтийн тайланг Санхүүгийн зохицуулах хорооны 2022 оны 03 дугаар сарын 29-ний өдрийн 1/1165 дугаар албан бичгээр Улсын Их Хурлын Тамгын газарт.

Улсын Их Хурлын Хяналт шалгалтын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.2 дахь хэсэг, Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 112 дугаар зүйлийн 112.3 дахь хэсэг, Улсын Их Хурлын Төрийн байгуулалтын байнгын хорооны 2013 оны “Системчилсэн үнэлгээ хийх тухай” 05 дугаар тогтоолын дагуу Улсын Их Хурлын Тамгын газраас Санхүүгийн зохицуулах хороо болон Санхүүгийн зохицуулах хорооны дэргэдэх хяналтын зөвлөлөөс ирүүлсэн дээрх тайланд дараах асуудлын хүрээнд шинжилгээ хийсэн болно. Үүнд:

1. Банкны үйл ажиллагаанаас бусад санхүүгийн үйлчилгээг зохицуулах, хянахтай холбогдсон хууль тогтоомжийн хэрэгжилтийн талаар;
2. Санхүүгийн зохицуулах хорооны 2021 оны үйл ажиллагааны тайланд системчилсэн үнэлгээ хийсэн эсэх талаар;
3. Банкны үйл ажиллагаанаас бусад санхүүгийн зах зээлийн зохицуулалт, хяналтад хамаарах чиглэлээр Монгол Улсын урт, дунд, богино хугацааны бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн талаар зэрэг болно.

НЭГ.БАНКНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНААС БУСАД САНХҮҮГИЙН ҮЙЛЧИЛГЭЭГ ЗОХИЦУУЛАХ, ХЯНАХТАЙ ХОЛБОГДСОН ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЛААР

Санхүүгийн зохицуулах хороо нь 2021 онд санхүүгийн зах зээлийн үйл ажиллагаатай холбоотой 27 хууль, 111 дүрэм, журам, зааврын хэрэгжилтийг хангаж ажилласнаас үнэт цаасны зах зээлд 55, даатгалын салбарт 25, банк бус санхүүгийн байгууллагын салбарт 16, хадгаламж зээлийн хоршооны салбарт 6, Үнэт металл, үнэт чулуу, тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгчдийн салбарт 6, нийт салбарт хамаарах 3 дүрэм, журам, зааврын хэрэгжилтийг хангаж ажилласан байна. Мөн Санхүүгийн зохицуулах хорооноос 2021 онд баталсан 7 захиргааны хэм хэмжээний актыг Захиргааны ерөнхий хуульд нийцүүлэн захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд бүртгүүлсэн байна.

Түүнчлэн 2021 онд банкны үйл ажиллагаанаас бусад санхүүгийн үйлчилгээг зохицуулах, хянахтай холбогдсон эрх зүйн орчныг боловсронгуй болгох чиглэлээр дараах хуулиуд батлагдсан. Үүнд:

- 2021 оны 01 дүгээр сарын 28-ны өдөр Банкны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль батлагдсанаар банкны хувьцаа эзэмшлийн төвлөрөл буурч, өмчлөл-удирдлага-хяналтын тэнцвэртэй байдлыг бүрдүүлэх, хөрөнгийн зах зээлийн хөгжилд эерэгээр нөлөөлөх олон давуу талыг бий болгох нөхцөл бүрдсэн. Үүний дагуу Банкны тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах хүрээнд хүсэлт ирүүлсэн 11 банкны төлөвлөгөөг бүрэн хянасан бөгөөд анхны нийтэд санал болгон гаргаж буй банкны хувьцааг бүртгэсэн;
- 2021 оны 05 дугаар сарын 21-ний өдөр Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, мөнгөн хөрөнгийн шилжүүлэг, зээлийн үйл ажиллагааны тухай хууль батлагдсан. Тус хуульд хөрвөх чадвартай хадгаламжийн сертификатыг бий болгох зохицуулалтыг тусгаснаар хөрөнгийн зах зээл дэх үнэт цаасны төрөл нэмэгдэх, хадгаламж эзэмшигч хүүний өгөөжөө тогтвортой хадгалах нөхцөл бүрдсэн;
- 2021 онд оны 12 дугаар сарын 17-ны өдөр Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн тухай хууль батлагдсанаар Монгол Улсад виртуал хөрөнгөтэй холбоотой үйл ажиллагааг эрхлэх эрх зүйн орчныг бүрдүүлж, эдийн засгийн өсөлтийг хангаж, хөгжлийг дэмжих, эрсдэлээс урьдчилан сэргийлэх, үйлчлүүлэгчдийн эрх ашгийг хамгаалах, гадаад хөрөнгө оруулалтын урсгалыг нэмэгдүүлэх нөхцөл бүрдсэн.

Харин тус салбарт хэрэгжиж буй дүрэм, журамтай холбоотой асуудлын талаар Санхүүгийн зохицуулах хорооны Хяналтын зөвлөлийн тайланд дурдсан бөгөөд Санхүүгийн зохицуулах хорооноос баталсан зарим эрх зүйн актуудыг “захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэл”-д бүртгүүлээгүй, хүчин төгөлдөр бус хэм хэмжээний актыг үндэслэн үүрэг, чиглэл өгдөг талаарх гомдлыг Хяналтын зөвлөлд ирүүлдэг тухай дурдсан байсан. Энэ талаар тодруулбал, санхүүгийн зах зээлийн үйл ажиллагаатай холбоотой 111 дүрэм, журам хэрэгжиж байгаагаас хэд нь хэм хэмжээ тогтоосон акт болох талаар, мөн нийт хэм хэмжээ тогтоосон актаас хэдийг Захиргааны ерөнхий хуульд нийцүүлэн “захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэл”-д бүртгүүлсэн талаар 2021 оны үйл ажиллагааны тайланд тодорхой тайлагнаагүй байна.

Захиргааны ерөнхий хуулийн 67 дугаар зүйлийн 67.1 дэх хэсэгт “Хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага улсын нэгдсэн бүртгэлд бүртгэсэн захиргааны хэм хэмжээний актыг бүртгэсэн өдрөөс хойш 10 өдрийн дотор “Захиргааны хэм хэмжээний актын эмхэтгэл”-д бүрэн эхээр нь нийтлүүлнэ”, 67.2 дахь хэсэгт “Захиргааны хэм хэмжээний актыг зөвхөн улсын нэгдсэн бүртгэлд бүртгэж, “Захиргааны хэм хэмжээний актын эмхэтгэл”-д нийтэлсний дараа хүчин төгөлдөр дагаж мөрдүүлнэ” гэж заасан тул хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллахад анхаарах шаардлагатай юм.

1.1.Хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих, Санхүүгийн зах зээлийн тогтвортой байдлыг хангах хүрээнд:

Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөл: Санхүүгийн зах зээлийн тогтвортой байдлыг хангах хүрээнд Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөл нь 2021 онд нийт 6 удаа хуралдаж, 15 асуудал хэлэлцэж холбогдох зөвлөмж, чиглэлийг гаргасан талаар тайлагнасан хэдий ч санхүүгийн зах зээлийн тогтвортой байдлыг хангах хүрээнд ямар үр дүнд хүрсэн талаар тодорхой тайлагнаагүй байна. Мөн зах зээлийн гэнэтийн таагүй

нөлөөлөл, хямралын үед эдийн засгийн өсөлт, хөгжлийг дэмжихэд чиглэгдсэн бодлого, үйл ажиллагаа нь үр дүнтэй байсан эсэх талаар тодорхой дурдаагүй байна.

Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөлийн бүрэлдэхүүнд Монголбанкны Ерөнхийлөгч, Сангийн сайд, Санхүүгийн зохицуулах хорооны дарга, Хадгаламжийн даатгалын корпорацын гүйцэтгэх захирал багтдаг бөгөөд Төвбанкны тухай хуулийн 27² дугаар зүйлд заасны дагуу зөвлөлийн үйл ажиллагааг Монголбанк хариуцан зохион байгуулах үүрэгтэй хэдий ч Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.2 дахь заалтад “бүрэн эрхийнхээ хүрээнд ... санхүүгийн зах зээлийн тогтвортой байдлыг дэмжих зорилгоор шаардлагатай шалгуур үзүүлэлт, бусад хэм хэмжээ тогтоох” гэж заасан тул хуульд заасан чиг үүргийн хүрээнд хэрэгжүүлсэн арга хэмжээ, үр дүнгийн талаар тодорхой тайлагнаагүй байна.

Хяналтын зөвлөл: Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1 дэх хэсэгт “Хорооны дэргэд Хорооноос гаргасан аливаа шийдвэртэй холбогдсон гомдлыг урьдчилан хянах, Хорооны үйл ажиллагаанд хяналт тавих чиг үүрэг бүхий орон тооны бус зөвлөл ажиллана” гэж заасан. Мөн Улсын Их Хурлын 2006 оны 56 дугаар тогтоолоор “Санхүүгийн зохицуулах хорооны дэргэдэх хяналтын зөвлөлийн ажиллах журам”-ыг баталсан.

Хяналтын зөвлөл нь дээрх журамд зааснаар дараах чиг үүргийг хэрэгжүүлэхээр тусгасан. Үүнд:

- Санхүүгийн зохицуулах хорооны жилийн санхүүгийн тайланд аудит хийх аудитын байгууллагыг сонгоход хяналт тавих;
- Аудитын дүгнэлт, зөвлөмжийг хэрэгжүүлэх талаар Санхүүгийн зохицуулах хорооноос хийж байгаа ажилтай танилцаж, биелэлтийг нь хянах;
- Хяналтын зөвлөлийн шийдвэрийн биелэлтэд хяналт тавих.

Санхүүгийн зохицуулах хорооны Хяналтын зөвлөлийн 2021 оны тайлангаас үзэхэд 2021 онд Санхүүгийн зохицуулах хорооны үйл ажиллагаатай холбоотой 6 албан бичиг, иргэд, аж ахуйн нэгжээс ирүүлсэн 11 гомдол, хүсэлтийг шийдвэрлэсэн талаар тайлагнасан.

Харин дээрх журамд заасан чиг үүргийн хүрээнд хэрэгжүүлсэн ажлын талаар тайлагнаагүй, түүнчлэн Хяналтын зөвлөл нь 2021 онд хэдэн удаа хуралдаж, ямар асуудлыг хэлэлцэн шийдвэрлэсэн нь тодорхойгүй байна.

Улсын Их Хурлын 2013 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн 72 дугаар тогтоолоор Хяналтын зөвлөлийн даргаар Р.Ринчинбазар, гишүүдээр Ж.Эрдэнэбилэг, А.Өнөржаргал, Б.Амарсанаа, Д.Цэрэнбадам нарыг томилсон. 2021 онд гишүүн Ж.Эрдэнэбилэг, Д.Цэрэнбадам нар Зөвлөлийн гишүүнээс чөлөөлөгдөх хүсэлтээ Улсын Их Хуралд хүргүүлж, гишүүн А.Өнөржаргал өвчний улмаас нас барсан тул Хяналтын зөвлөл нь одоогоор дарга, нэг гишүүний бүрэлдэхүүнтэй ажиллаж байна.

1.2. Банкны үйл ажиллагаанаас бусад санхүүгийн зах зээлийн 2021 оны үйл ажиллагаа, үр дүн:

2021 онд банкны үйл ажиллагаанаас бусад санхүүгийн зах зээлийн салбарт хэрэгжүүлсэн бодлого, үйл ажиллагааны үр дүнд Санхүүгийн зохицуулах хорооны зохицуулалтад хамаарах санхүүгийн салбарын ДНБ-д эзлэх хувь 2021 онд 24 хувьд хүрсэн байна. Санхүүгийн зах зээл дээх 6 салбарын голлох үзүүлэлтүүдийг тоймлон авч үзвэл:

Хөрөнгийн зах зээл: Хөрөнгийн зах зээлд 579 зохицуулалттай этгээд үйл ажиллагаа эрхэлж байгаагаас 2021 онд Санхүүгийн зохицуулах хорооноос 31 тусгай

зөвшөөрөл, 4 зөвшөөрөл олгож, 9 хуулийн этгээдийг үнэт цаасны зах зээлд оролцогчдод үйлчилгээ үзүүлэгчээр бүртгэжээ.

2021 онд үнэт цаасны зах зээлийн үнэлгээ 95.8 хувиар өсөж 6.0 их наяд төгрөгт хүрч, үнэт цаасны арилжаа 21.6 дахин өссөн байна.

Монголын хөрөнгийн биржийн анхдагч болон хоёрдогч зах зээлийн арилжаагаар нийт 733.3 сая ширхэг хувьцааг 304.9 тэрбум төгрөгөөр, компанийн бондын анхдагч болон хоёрдогч зах зээлийн арилжаагаар нийт 1.05 их наяд төгрөгийн, хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрхийн анхдагч болон хоёрдогч зах зээлийн арилжаагаар 56.8 тэрбум төгрөгийн арилжааг тус тус хийжээ.

Мөн хөдөө аж ахуйн биржээр нийт 794.56 тэрбум төгрөгийн бараа бүтээгдэхүүн арилжаалагдсан нь өмнөх оноос 305.86 тэрбум төгрөгөөр буюу 62.59 хувиар өссөн байна.

Даатгалын зах зээл: Даатгалын зах зээлд 15 даатгалын компани, 1 урт хугацааны даатгалын компани, 1 давхар даатгалын компани, 57 даатгалын зуучлагч, 25 хохирол үнэлэгч, 43 аудитын компани, 36 актуарч, 144 аудитор, 2403 даатгалын төлөөлөгч Санхүүгийн зохицуулах хорооноос олгосон зөвшөөрлийн хүрээнд үйл ажиллагаа эрхэлж байна.

2021 онд даатгуулагчдын тоо 10 хувиар нэмэгдэж, ердийн, урт хугацааны, давхар даатгалын компаниудын нийт хөрөнгө 425.4 тэрбум төгрөгт хүрсэн нь өмнөх оноос 43.3 тэрбум төгрөг буюу 11.3 хувиар, даатгалын тохиолдлын улмаас 68.9 тэрбум төгрөгийн нөхөн төлбөр олгосон нь өмнөх оноос 9.1 тэрбум төгрөг буюу 15.2 хувиар тус тус өсжээ. Түүнчлэн 2021 онд даатгалын компаниуд 25.0 тэрбум төгрөгийн цэвэр ашигтай ажиллаж, нийт нөөцийн сангийн хэмжээ 193.7 тэрбум төгрөгт хүрсэн нь өмнөх оноос 20.2 тэрбум төгрөг буюу 11.6 хувиар өсжээ.

Банк бус санхүүгийн байгууллагын салбар: 2021 оны жилийн эцсийн байдлаар 21790 хувьцаа эзэмшигчдийн 534 банк бус санхүүгийн байгууллага үйл ажиллагаа явуулж байна. 2021 онд банк бус санхүүгийн байгууллагын тоо 0.3 хувиар өссөн үзүүлэлттэй байна. Мөн нийт харилцагчдын тоо 4.8 сая буюу 1.7 дахин, нийт зээлдэгчдийн тоо 1.7 сая буюу 2.1 дахин тус тус өссөн байна.

Банк бус санхүүгийн байгууллагуудын нийт хөрөнгийн хэмжээ 2.7 их наяд төгрөгт хүрч өмнөх оноос 35 хувиар өссөн нь банкны салбарын 6.6 хувьтай тэнцэж байна. Мөн өмнөх онтой харьцуулахад нийт орлогын хэмжээ 27.5 тэрбум төгрөгөөр, нийт зардлын хэмжээ 57.5 тэрбум төгрөгөөр, цэвэр ашгийн хэмжээ 55.0 тэрбум төгрөгөөр тус тус нэмэгдсэн үзүүлэлттэй гарчээ.

2021 онд нийт 2.0 их наяд төгрөгийн зээл олгосон нь өмнөх оноос 0.7 их наяд төгрөгөөр, нийт зээлдэгчдийн тоо 911.9 мянгаар тус тус нэмэгджээ. Түүнчлэн зээлийн жигнэсэн дундаж хүү 2.7 хувь болж өмнөх оноос 0.1 пунктээр, чанаргүй зээлийн нийт зээлд эзлэх үзүүлэлт 7 хувьд хүрч өмнөх оноос 3.3 пунктээр тус тус буурсан эерэг үзүүлэлттэй байна.

Хадгаламж, зээлийн хоршооны салбар: 2021 оны жилийн эцсийн байдлаар 209 хадгаламж, зээлийн хоршоо үйл ажиллагаа явуулж байгаа нь өмнөх оноос 40-өөр бага буюу 16 хувиар буурсан үзүүлэлттэй гарсан хэдий ч хадгаламж, зээлийн хоршоодын гишүүдийн тоо 75400 болж өмнөх оноос 3.7 хувиар, нийт хөрөнгийн хэмжээ 291.2 тэрбум төгрөгт хүрч өмнөх оноос 37.3 хувиар тус тус өссөн үзүүлэлттэй гарчээ. Мөн нийт хадгаламжийн хэмжээ 203.5 тэрбум төгрөг хүрч өмнөх оноос 11.7 хувиар, нийт зээлийн хэмжээ 213.4 тэрбум төгрөгт хүрч өмнөх оноос 27.4 хувиар тус тус өсжээ.

Түүнчлэн зээлийн жигнэсэн дундаж хүү 2.2 хувь болж өмнөх оноос 0.8 пунктээр, чанаргүй зээлийн нийт зээлд эзлэх үзүүлэлт 3.5 хувьд хүрч өмнөх оноос 0.9 пунктээр тус тус буурсан эерэг үзүүлэлттэй байна.

Үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын салбар: Тус салбарт Санхүүгийн зохицуулах хорооноос үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын байгууллагын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авсан 248 хуулийн этгээд үйл ажиллагаа эрхэлж энэ хүрээнд нийт 269 брокер, 1367 агент ажиллажээ.

2021 онд нийт 6274 хэлцэл бүхий 1,302.5 мянган м.кв талбай бүхий үл хөдлөх эд хөрөнгийг 852.6 тэрбум төгрөгөөр худалдах, худалдан авах үйл ажиллагаа зуучилж, 2114 хэлцэл бүхий 186.4 мянган м.кв талбай бүхий үл хөдлөх эд хөрөнгийг 23.6 тэрбум төгрөгөөр хөлслүүлж, түрээслүүлэх үйл ажиллагааг тус тус зуучилсан байна.

Үнэт металл, үнэт чулуу, тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгчдийн салбар: Санхүүгийн зохицуулах хорооноос 40 хуулийн этгээд, 436 иргэн үнэт металл, үнэт чулуу, тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй байгаа нь хуулийн этгээд өмнөх оноос 25 хувиар, иргэн 8.5 хувиар тус тус өссөн үзүүлэлттэй гарчээ.

Харин 2021 оны жилийн эцсийн байдлаар 3.9 тонн алтыг 583.6 тэрбум төгрөгөөр худалдан авсан нь өмнөх оноос 150.2 тэрбум төгрөгөөр буурсан, 694.2 тэрбум төгрөгийн үнийн дүнтэй алт борлуулсан нь өмнөх оноос 313.5 тэрбум төгрөгөөр тус тус буурсан үзүүлэлттэй байна.

1.3. Санхүүгийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл олгох, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох, тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлагыг биелүүлж байгаа эсэхэд хяналт тавих чиг үүргийн хүрээнд:

Санхүүгийн зохицуулах хороонд 2021 онд давхардсан тоогоор 1278 хуулийн этгээдээс тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл, бүртгэлийн хүсэлтийг цахимаар ирүүлснээс баримт бичгийн бүрдэл хангаагүй 323 хүсэлтийг буцааж, шаардлага хангасан 955 хүсэлтийг хүлээн авч, холбогдох бүртгэл, зөвшөөрлийг хийжээ.

Мөн хяналт тавих чиг үүргийн хүрээнд газар дээрх шалгалтыг 191 удаа зохион байгуулж, давхардсан тоогоор сар, улирлын 10,509 санхүүгийн болон зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийн тайлан, мэдээнд зайны хяналт хийсэн байна.

Улсын байцаагчийн шаардлагын биелэлт, захиргааны хариуцлага ногдуулалтын биелэлтийг хангуулах талаар хяналт тавьж ажиллах хүрээнд 2021 онд нийт 327 улсын байцаагчийн албан шаардлага хүргүүлснээс үнэт цаасны хяналтын чиглэлээр 81, банк бус санхүүгийн байгууллагын хяналтын чиглэлээр 151, хадгаламж, зээлийн хоршооны хяналтын чиглэлээр 41, даатгалын хяналтын чиглэлээр 8, үл хөдлөх хөрөнгө зуучлал, үнэт эдлэлийн чиглэлээр 16, мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх чиглэлээр 30 шаардлагыг тус тус хүргүүлж, биелэлтийг хангуулан ажилласан байна.

Түүнчлэн нэр бүхий 8 хуулийн этгээдэд зөрчлийн хэрэг нээж үүнээс 5 хуулийн этгээдэд Зөрчлийн тухай хуульд заасны дагуу торгууль ногдуулж, үйл ажиллагааг нь зогсоосон байна. Мөн 2021 онд Санхүүгийн зохицуулах хороо нь 15 хэрэг, маргаанд нэхэмжлэгч, хариуцагчаар оролцсоноор 11 хэрэг шийдвэрлэгдэж, 4 хэрэг хяналтын шатанд байна.

1.4. Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийг хэрэгжүүлж байгаа эсэхэд хяналт тавих хүрээнд:

2021 онд үндэсний эрсдэлийн үнэлгээг хийж гүйцэтгэсний үр дүнд Монгол Улсыг 2021 оны 7 дугаар сард Ази, номхон далайн мөнгө угаахтай тэмцэх бүлгээс гаргасан “Дахин үнэлгээний тайлан”-д **“хэсэгчлэн биелүүлсэн”** үнэлгээг 1 шатаар ахиулж **“ихэнхийг биелүүлсэн”** үнэлгээ өгсөн буюу хуулийн хэрэгжилтийг хангах хүрээнд 2021 онд үр дүнтэй ажилласан байна.

Мөн мэдээлэх үүрэгтэй этгээд тус бүрийн эрсдэлийг тогтмол үнэлэх, зохицуулалттай үйл ажиллагаа эрхэлж буй 6 салбарт мэдээллийн санг нэвтрүүлэх “Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх, үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх эрсдэлийн үнэлгээний асуулга”-ыг боловсронгуй болгох зэрэг ажлуудыг хийжээ.

Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх чиглэлээр хяналт шалгалтыг тасалдуулахгүй, тасралтгүй хэлбэрээр үргэлжлүүлэх, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах зорилгоор хяналт шалгалтын зайны эрчимжүүлсэн хэлбэрт шилжиж 2021 онд нийт 1,562 этгээдийг хамруулж, зөрчил илэрсэн этгээдүүдэд нийт 30 удаа улсын байцаагчийн албан шаардлагыг хүргүүлж, хугацаатай үүрэг даалгавар өгсөн байна.

Түүнчлэн Санхүүгийн зохицуулах хороо нь мэргэжлийн холбоод, төрийн болон хувийн хэвшлийн байгууллагууд, олон улсын байгууллагуудтай хамтран 2021 онд 44 удаагийн сургалт, хэлэлцүүлгийг зохион байгуулж 4,360 этгээдийг хамруулсан байна.

1.5.Технологид суурилсан санхүүгийн шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээ, бизнес загварыг хязгаарлагдмал хүрээнд бодитоор турших, нэвтрүүлэх сэндрбокс зохицуулалтын орчинг бий болгох хүрээнд:

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.12 дахь заалтыг хэрэгжүүлэх хүрээнд санхүүгийн үйлчилгээнд шинээр нэвтэрч буй технологид суурилсан шинэлэг бүтээгдэхүүн, үйлчилгээ, бизнес загварыг дотоодын санхүүгийн зах зээлд нэвтрүүлэх, сэндрбокс зохицуулалтын орчинг бүрдүүлэх зорилгоор “Сэндрбокс зохицуулалтын орчны журам”-ыг боловсруулж Монголбанкны ерөнхийлөгч, Санхүүгийн зохицуулах хорооны дарга, Сангийн сайд, Хадгаламжийн даатгалын корпорацийн гүйцэтгэх захирлын хамтарсан 2021 оны 03 дугаар сарын 01-ний өдрийн А-63/64/32/А/27 тушаалаар баталжээ.

Тус журамд Санхүүгийн зохицуулах хороо, Монголбанкны зохицуулалт дор хязгаарлагдмал хүрээг хамарсан бодит орчинд тодорхой цаг хугацаанд турших боломж олгох, оролцогчдод тавигдах шаардлагыг тодорхойлох болон холбогдох бусад харилцааг зохицуулахаар тусгасан байна.

Түүнчлэн “Сэндрбоксын зөвлөлийн дүрэм”-ийг Монголбанкны Ерөнхийлөгч, Санхүүгийн зохицуулах хорооны даргын 2021 оны 09 дүгээр сарын 24-ний өдрийн А251/252 дугаар хамтарсан тушаалаар баталж, зөвлөл байгуулагдсанаар сэндрбоксын орчинд турших анхны бүтээгдэхүүнийг бүртгэж, дижитал өрийн хэрэгсэл зах зээлд гаргажээ.

Санхүүгийн зах зээлд сэндрбоксын орчинг нэвтрүүлэх нь шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээг зах зээлд нэвтрүүлэх, турших боломжийг нээх ач холбогдолтой тул финтекийн хөгжлөөр тэргүүлэгч улс орнууд сэндрбокс орчныг зохицуулалтын оновчтой арга хэрэгсэл гэж үздэг. Иймд 2021 онд сэндрбоксын орчинг анх удаа нэвтрүүлсэн нь банкны үйл ажиллагаанаас бусад санхүүгийн зах зээлийн хөгжилд хувь нэмэр оруулахад ач холбогдол бүхий шийдвэр, үйл ажиллагаа болжээ.

1.6.Хөрөнгө оруулагч, үйлчлүүлэгчдийн эрх ашгийг хамгаалах, санхүүгийн мэдлэгийг дээшлүүлэх хүрээнд:

2021 онд зээлийн батлан даалтын сангийн үйл ажиллагааг эрчимжүүлэх, хүртээмжийг нэмэгдүүлэх чиглэлээр “Зээлийн батлан даалтын сангийн үйл ажиллагааг зохицуулах, хяналт тавих, журам”-д 2 удаа өөрчлөлт оруулж, нийт 590 жижиг, дунд үйлдвэр эрхлэгчдэд 85.3 тэрбум төгрөгийн батлан даалт гаргаснаар 167.1 тэрбум төгрөгийн зээл олгогдсон байна.

Мөн “Эрүүл мэндээ хамгаалж, эдийн засгаа сэргээх 10 их наядын цогц төлөвлөгөө”-ний хүрээнд Зээлийн батлан даалтын сан нь “Ажлын байрыг дэмжих зээл” зориулалтаар 208 зээлдэгчийн 57.1 тэрбум төгрөгийн зээлд 28.4 тэрбум төгрөгийн батлан даалт гаргажээ.

Түүнчлэн харилцагчийн хохирол барагдуулах талаар өгсөн үүрэг чиглэлийн хүрээнд даатгалтай холбоотой 89 иргэн, хуулийн этгээдэд 833.7 сая төгрөгийн нөхөн төлбөрийг олгохоор урьдчилан шийдвэрлэсэнээс, даатгагч 29 иргэн, хуулийн этгээдэд 117.2 сая төгрөгийн нөхөн төлбөрийг олгосон байна.

Санхүүгийн зохицуулах хороо нь иргэдийн санхүүгийн боловсролыг дээшлүүлэх хүрээнд өөрийн вэбсайт, пэйж, твиттер хаяг болон ikon.mn сайтын “Санхүүгийн боловсрол”, eagle.mn сайтын “Эдийн засаг” буланд иргэдэд санхүүгийн мэдлэг олгох мэдээллийг тогтмол байршуулж ажиллажээ. Мөн иргэдийн болон санхүүгийн зохицуулах хорооны албан хаагчдад зориулсан 76 удаагийн сургалт, семинар, хэлэлцүүлгийг зохион байгуулж, 6 төрлийн гарын авлага, 5 төрлийн брошур зэргийг хэвлэн нийтлүүлжээ.

Хэдийгээр иргэдийн санхүүгийн мэдлэг, мэдээллийг дээшлүүлэхэд чиглэсэн олон арга хэмжээг холбогдох төрийн байгууллагуудаас төлөвлөн хэрэгжүүлж байгаа хэдий ч сүүлийн жилүүдэд иргэдийн санхүүгийн мэдлэг дутмаг байдлыг ашиглах, үнийн санаатай манипуляци хийх, хууран мэхлэх зэрэг эдийн засгийн гэмт хэргийн тоо жил ирэх бүр өссөн үзүүлэлттэй байна.

ХОЁР.САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ 2021 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАНД СИСТЕМЧИЛСЭН ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН ЭСЭХ ТАЛААР

Улсын Их Хурлын Төрийн байгуулалтын байнгын хорооны 2013 оны “Системчилсэн үнэлгээ хийх тухай” 05 дугаар тогтоолоор Улсын Их Хуралд ажлаа хариуцан тайлагнадаг байгууллагуудад үйл ажиллагааны тайлангаа Улсын Их Хуралд ирүүлэхдээ “Байгууллагын үйл ажиллагаанд системчилсэн үнэлгээ хийх аргачлал”-ын дагуу үнэлгээ хийж ирүүлэх үүрэг өгсөн. Энэ хүрээнд Санхүүгийн зохицуулах хороо нь 2021 оны үйл ажиллагааны тайландаа системчилсэн үнэлгээ хийхдээ байгууллагынхаа үйл ажиллагааг бүхэлд нь хамруулан үнэлгээ хийжээ.

Санхүүгийн зохицуулах хороо нь 2021 онд 9 газар, 4 хэлтэс, 4 албанд нийт 163 албан хаагчтайгаар 6 салбарын 3447 зохицуулалттай этгээд, 2406 даатгалын төлөөлөгчдөд хяналт тавьж ажилласан байна.

Мөн орон нутагт үйл ажиллагаа эрхэлж буй зохицуулалтын байгууллагуудын нэгдсэн бүртгэл хөтөлж, шаардлагатай мэдээллүүдийг тогтоосон хугацаанд Санхүүгийн зохицуулах хороонд ирүүлэх, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах, Санхүүгийн зохицуулах хорооноос өгсөн чиглэлийн дагуу зохицуулалтын байгууллагуудад хяналт тавих үүрэг бүхий орон нутгийн 63 төлөөлөгчид Монгол Улсын 21 аймаг, 9 дүүрэгт ажиллажээ.

Санхүүгийн зохицуулах хороо нь 2021 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 8 хэсэг бүхий нийт 212 зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусгаж, нийт хэрэгжилт 95.0 хувь буюу “Тодорхой үр дүнд хүрсэн” үнэлгээтэй байна. Мөн бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг хангах хүрээнд 7 тогтоол, шийдвэрийн 191 заалтын биелэлтийг холбогдох байгууллагуудад хуулийн хугацаанд 89.6 хувийн гүйцэтгэлтэй хүргүүлж ажиллажээ.

Санхүү төсөв: Монгол Улсын 2021 оны Төсвийн тухай хуулиар Санхүүгийн зохицуулах хорооны багцад 7,102.7 сая төгрөгийн төсөв батлагдсанаас 76 хувийг улсын төсвийн санхүүжилтийн, 24 хувийг үндсэн үйл ажиллагааны орлого буюу зохицуулалтын үйлчилгээний хураамжийн эх үүсвэрээр бүрдүүлэхээр төлөвлөснөөс нийт орлогын гүйцэтгэл 6,081.7 сая төгрөг, нийт бараа үйлчилгээний зардлын дүн 5,717.6 сая төгрөг, мөнгөн хөрөнгийн эцсийн үлдэгдэл 491,418.2 сая төгрөг буюу 86 хувийн төсвийн гүйцэтгэлтэй тайлагнажээ.

Тайлант хугацаанд зохицуулалт үйлчилгээний орлогод 3,257.6 сая төгрөгийг төвлөрүүлсэн нь өмнөх онтой харьцуулахад 35.5 хувиар өссөн дүнтэй байна. Нийт орлогыг ангилан харуулбал:

- ББСБ-ын салбар 1,289.0 сая төгрөг буюу 39.5 хувь;
- Даатгалын салбар 704.3 сая төгрөг буюу 21.6 хувь;
- Үнэт цаасны салбар 1,179.6 сая төгрөг буюу 36.2 хувь;
- Хадгаламж, зээлийн хоршооны салбар 33.7 сая төгрөг буюу 1.0 хувь;
- Үл хөдлөх хөрөнгө зуучлал, үнэт эдлэлийн байгууллага 49.5 сая төгрөг буюу 1.5 хувь;
- Бусад орлого 1.4 сая төгрөг 0.04 хувь.

Улсын төсөвт 54.8 сая төгрөгийн тэмдэгтийн хураамжийн орлогыг төвлөрүүлсэн нь өмнөх онтой харьцуулахад 26.3 хувиар өссөн үзүүлэлттэй байгаа бол, 224.9 сая төгрөгийн торгуулийн орлого төвлөрүүлсэн нь өмнөх онтой харьцуулахад 36.1 хувиар буурсан үзүүлэлттэй байна.

Гадаад харилцаа, хамтын ажиллагаа: Монгол Улсын санхүүгийн салбар, хөрөнгийн зах зээлийг тогтвортой, ногоон хөгжлийн үзэл баримтлалтай уялдуулан хөгжүүлэх зорилгоор Санхүүгийн зохицуулах хороо, Монголын тогтвортой санхүүжилтийн хөгжлийн холбоо харилцан ойлголцлын санамж бичгийг 2021 оны 11 дүгээр сарын 25-ны өдөр байгуулсан. Энэхүү санамж бичгийн хүрээнд “Монгол Улсын Тогтвортой санхүүжилтийн зорилт”-уудын санхүүжилтийн таксономийг НҮБ-ын хөгжлийн хөтөлбөр болон холбогдох талуудын саналыг тусган хамтран боловсруулахаар төлөвлөсөн байна.

Мөн Олон Улсын Санхүүгийн Корпорацтай Ногоон санхүүжилтийн зах зээлийг хөгжүүлэх, Нийлүүлэлтийн сүлжээний санхүүжилтийн зах зээлийг хөгжүүлэх төслүүдийг хамтран хэрэгжүүлэхээр 2020 оны 5 дугаар сарын 15-ны өдөр байгуулсан “Харилцан ойлголцлын санамж бичиг”-ийн хүрээнд Санхүүгийн зохицуулах хорооны 2021 оны 06 дугаар сарын 11-ний өдрийн 226 дугаар тогтоолоор баталсан “Компанийн өрийн хэрэгслийн бүртгэлийн журам”-д “Ногоон бонд”-ын зохицуулалтыг нэмж тусган баталсан байна.

Түүнчлэн гадаадын ижил төстэй байгууллагуудын хамтын ажиллагааны хүрээнд Олон улсын “Санхүүгийн хүртээмжийн нийгэмлэг /AFI”, Үнэт цаасны хороодын олон улсын байгууллага /IOSCO/, Олон улсын даатгалын зохицуулагчдын холбоо /IAIS/, Японы Санхүүгийн үйлчилгээний агентлаг /FSA/, Азийн хөгжлийн банк /ADB/, Олон улсын санхүүгийн корпорац /IFC/, ХБНГУ-ын Олон улсын хамтын ажиллагааны нийгэмлэг /GIZ/, Хүртээмжтэй даатгалын асуудлаарх Азийн орнуудын мэдлэг туршлага солилцох сүлжээ /MEFIN/, БНЭУ-ын Үнэт цаас, биржийн хороо /Securities Exchange Board of India/ болон Даатгалын зохицуулалт, хөгжлийн газар /Insurance Regulatory and Development Authority/, Европын сэргээн босголт хөгжлийн банк /EBRD/-уудтай хамтын ажиллагааг үргэлжлүүлэн, эрчимжүүлж ажиллахад анхаарч ажиллажээ.

Түүнчлэн олон улсын байгууллагаас санхүүжүүлж буй төсөл хөтөлбөрийг хэрэгжүүлэх хүрээнд Дэлхийн банкнаас хэрэгжүүлж буй “Төсөв санхүүгийн тогтвортой

байдлыг бэхжүүлэх төсөл”, Японы Хамтын ажиллагааны агентлаг /JICA/-тай хамтран “Хөрөнгийн зах зээлийн чадавхыг бэхжүүлэх төсөл”, АХБ-тай хамтран хэрэгжүүлж буй “Бичил санхүүгийн байгууллагыг чадавхжуулах, санхүүгийн хүртээмжийг нэмэгдүүлэх төсөл”-ийн хэрэгжилтийг хангаж ажиллажээ.

Харин хуульд заасан чиг үүргийн хүрээнд дотоод үйл ажиллагаатай холбоотой хэрэгжүүлэх үүрэгтэй үйл ажиллагааны талаар авч үзвэл, Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.7 дахь заалтад “Хорооны ажилтны ёс зүйн дүрмийг баталж, биелэлтэд нь хяналт тавих” гэж заасан. Гэвч Санхүүгийн зохицуулах хорооны 2021 оны системчилсэн үнэлгээний тайланд ажилтны ёс зүйн дүрмийн хэрэгжилтэд хяналт тавьж ажилласан эсэх талаар тодорхой тайлагнаагүй байна.

Түүнчлэн системчилсэн үнэлгээний зорилго нь байгууллагын үйл ажиллагааны үр өгөөж, өөрийн тавьсан зорилгодоо ямар хэмжээнд хүрсэн байдлыг тодорхойлох буюу тухайн байгууллагын дотоод үйл ажиллагааг үнэлэхэд чиглэгддэг. Харин санхүүгийн зохицуулах хорооны 2021 оны системчлэн үнэлгээний тайлангаа үйл ажиллагааны тайлан хэлбэрээр тайлагнасан байна.

ГУРАВ. БАНКНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНААС БУСАД САНХҮҮГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ЗОХИЦУУЛАЛТ, ХЯНАЛТАД ХАМААРАХ ЧИГЛЭЛЭЭР МОНГОЛ УЛСЫН УРТ, ДУНД, БОГИНО ХУГАЦААНЫ БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГТ ТУСГАСАН ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТИЙН ТАЛААР

Санхүүгийн зохицуулах хорооны 2022 оны 03 дугаар сарын 29-ний өдрийн 1/1165 дугаартай албан бичгээр ирүүлсэн банкны үйл ажиллагаанаас бусад санхүүгийн зах зээлийн зохицуулалт, хяналтад хамаарах чиглэлээр Монгол Улсын урт, дунд, богино хугацааны дараах бодлогын баримт бичгийн 2021 оны хэрэгжилтийг ирүүлжээ.

1.“Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын 2021 оны хэрэгжилтийн байдлыг авч үзвэл банкны үйл ажиллагаанаас бусад санхүүгийн зах зээлийн зохицуулалт, хяналтад хамаарах чиглэлээр нийт 4 чиглэлийн хүрээнд 41 зорилт, үйл ажиллагааг төлөвлөснөөс 2021 оны зорилтот түвшинг хэрэгжилтийн байдалтай харьцуулж үзвэл 95.7 хувийн хэрэгжилттэй гэж үнэлжээ.

Хүснэгт 1. Банкны үйл ажиллагаанаас бусад санхүүгийн зах зээлийн зохицуулалт, хяналтад хамаарах чиглэлээр “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогод тусгасан зорилтын 2021 оны хэрэгжилт

| Д/д | Бодлогын чиглэл | Зорилтын тоо | 2021 оны зорилтот түвшинтэй харьцуулсан үнэлгээ | Нэгдсэн үнэлгээ |
|-----|--|--------------|---|-----------------|
| 1. | Хөрөнгийн зах зээл; | 12 | 95.0% | 95.7% |
| 2. | Даатгалын салбар; | 15 | 92.0% | |
| 3. | Бичил санхүүгийн салбар; | 12 | 95.8% | |
| 4. | Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх. | 2 | 100.0% | |

2.Зээлийн хүүг бууруулах стратеги батлах тухай Улсын Их Хурлын 2020 оны 21 дүгээр тогтоолоор 4 чиглэлийн хүрээнд 17 дэд арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 2021 оны хэрэгжилтийн байдлыг авч үзвэл 98.0 хувийн хэрэгжилттэй гэж үнэлжээ.

Хүснэгт 2. Зээлийн хүүг бууруулах стратеги батлах тухай Улсын Их Хурлын 2020 оны 21 дүгээр тогтоолын 2021 оны хэрэгжилт

| Д/д | Чиглэл | Дэд арга хэмжээ | 2021 оны хэрэгжилтийн үнэлгээ | Нэгдсэн үнэлгээ |
|-----|---|-----------------|-------------------------------|-----------------|
| 1. | Зээлийн эх үүсвэрийн зардлыг бууруулах макро тогтвортой орчныг бүрдүүлэх; | 5 | 95.0% | 98.0% |
| 2. | Зээлийн эрсдэлийн зардлыг бууруулах; | 5 | 97.0% | |
| 3. | Банкны үйл ажиллагааны зардлыг бууруулах; | 3 | 100.0% | |
| 4. | Хөрөнгийн зах зээлийг хөгжүүлэх, өрсөлдөөнийг бий болгож санхүүжилтийн зардлыг бууруулах. | 4 | 100.0% | |

3.Төрөөс мөнгөний бодлогын талаар 2021 онд баримтлах үндсэн чиглэл батлах тухай Улсын Их Хурлын 2020 оны 32 дугаар тогтоолоор нийт 8 чиглэлийг баталсанаас Санхүүгийн зохицуулах хорооны эрхлэх асуудлын хүрээнд хамаарах 6 чиглэлийн 2021 оны хэрэгжилтийн байдлыг авч үзвэл 97.6 хувийн хэрэгжилттэй гэж үнэлжээ.

Хүснэгт 3. Төрөөс мөнгөний бодлогын талаар 2021 онд баримтлах үндсэн чиглэл батлах тухай Улсын Их Хурлын 2020 оны 32 дугаар тогтоолын 2021 оны хэрэгжилт

| Д/д | Чиглэл | 2021 оны хэрэгжилтийн үнэлгээ | Нэгдсэн үнэлгээ |
|-----|---|-------------------------------|-----------------|
| 1. | Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тогтолцоог сайжруулах хүрээнд хууль, эрх зүйн орчныг Санхүүгийн хориг арга хэмжээ авах байгууллага /ФАТФ/-ын зөвлөмжтэй нийцүүлэн боловсронгуй болгох, Монгол Улсын үнэлгээний үр дүнтэй байдлыг дээшлүүлэх зорилгоор олон улсын болон дотоодын байгууллагуудтай хамтран ажиллах, үндэсний хөтөлбөрийг батлах; | 100.0% | 97.6% |
| 2. | Санхүүгийн хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах эрх зүйн орчныг сайжруулж, санхүүгийн маргааныг олон улсын шилдэг туршлагад үндэслэн шийдвэрлэх оновчтой тогтолцоог бүрдүүлэх; | 95.0% | |
| 3. | Банк, санхүүгийн үйлчилгээний цахим шилжилтийг эрчимжүүлэх; | 98.0% | |
| 4. | Олон улсын шилдэг туршлагад үндэслэн орон сууцны ипотекийн зээлийн санхүүжилтийн тогтолцоог бүрдүүлэх; | 100.0% | |
| 5. | Монгол Улсын Их Хурлын 2020 оны 8 дугаар сарын 28-ны өдрийн 21 дүгээр тогтоолоор баталсан “Зээлийн хүүг бууруулах стратеги”-ийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг боловсруулан хэрэгжилтийг хангах; | 95.0% | |
| 6. | Цар тахлаас үүдсэн эдийн засгийн хүндрэлийн үед импортыг орлох, экспортыг төрөлжүүлэх, хөдөө аж ахуйн гаралтай бүтээгдэхүүний үйлдвэрлэлтийг нэмэгдүүлэх, эдийн засгийг идэвхжүүлэхэд чиглэсэн мөнгө, санхүү, төсвийн бодлогыг хэрэгжүүлэх. | 97.5% | |

4. Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлын үед санхүү, эдийн засгийн тогтвортой байдлыг хангах, эрсдэлээс урьдчилан сэргийлэх, төрийн үйлчилгээнд цахим шилжилт хийх арга хэмжээний тухай Улсын Их Хурлын 2020 оны 32 дугаар тогтоолоор 9 чиглэлийн хүрээнд 20 арга хэмжээг төлөвлөснөөс Санхүүгийн зохицуулах хорооны эрхлэх асуудлын хүрээнд хамаарах 4 чиглэлийн хэрэгжилтийн байдлыг авч үзвэл 96.6 хувийн хэрэгжилттэй гэж үнэлжээ.

Хүснэгт 4. Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлын үед санхүү, эдийн засгийн тогтвортой байдлыг хангах, эрсдэлээс урьдчилан сэргийлэх, төрийн үйлчилгээнд цахим шилжилт хийх арга хэмжээний тухай Улсын Их Хурлын 2020 оны 32 дугаар тогтоолын 2021 оны хэрэгжилт

| Д/д | Чиглэл | Арга хэмжээ | 2021 оны хэрэгжилтийн | Нэгдсэн үнэлгээ |
|-----|--------|-------------|-----------------------|-----------------|
|-----|--------|-------------|-----------------------|-----------------|

| | | | үнэлгээ | |
|----|---|---|---------|-------|
| 1. | Мөнгө хүүлэлтийг хязгаарлах замаар зээлдэгчийн эрхийг хамгаалах эрх зүйн орчныг бүрдүүлэх; | 1 | 100.0% | 96.6% |
| 2. | Жижиг, дунд үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчдийн бизнесийн үйл ажиллагааг дэмжих зорилгоор зээлийн батлан даалтын сангийн үйл ажиллагааг эрчимжүүлэх, хүртээмжийг нэмэгдүүлэх; | 3 | 90.0% | |
| 3. | Банкнаас бусад санхүүгийн салбарыг хөгжүүлэх; | 1 | - | |
| 4. | Төрийн үйлчилгээний болон төрийн тусгай албан хаагчдад зориулсан ипотекийн зээлийн шинэ бүтээгдэхүүн гаргах, орон сууцны ипотекийн зээлийн санхүүжилтийн хүртээмжийг нэмэгдүүлэх. | 3 | 100.0% | |

ДӨРӨВ.ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ

Монгол Улсын Их Хурлын Хяналт шалгалтын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.2 дахь хэсэг, Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 112 дугаар зүйлийн 112.3 дахь хэсэгт заасны дагуу Улсын Их Хурлын Тамгын газраас Санхүүгийн зохицуулах хорооны 2021 оны тайланд шинжилгээ хийлээ.

Шинжилгээг хийхдээ Санхүүгийн зохицуулах хорооны 2021 оны үйл ажиллагааны тайлан, Санхүүгийн зохицуулах хорооны дэргэдэх хяналтын зөвлөлийн 2021 оны үйл ажиллагааны тайлан болон Банкны үйл ажиллагаанаас бусад санхүүгийн зах зээлийн зохицуулалт, хяналтад хамаарах чиглэлээр Монгол Улсын урт, дунд, богино хугацааны бодлогын баримт бичигт тусгагдсан зорилт, арга хэмжээний хэрэгжилтийн тайлангийн хүрээнд гүйцэтгэж, дараах дүгнэлт, зөвлөмжийг хүргүүлж байна. Үүнд:

1. Санхүүгийн зохицуулах хорооны зохицуулалтад хамаарах санхүүгийн салбарын ДНБ-д эзлэх хувь 2021 онд 24 хувьд хүрсэн нь өмнөх онтой харьцуулахад 8.7 хувиар өссөн үзүүлэлттэй байна;
2. 2021 онд зохицуулалттай үйл ажиллагаа эрхэлж буй 6 салбарын үнэт металлын салбараас бусад салбарын үзүүлэлтүүд өссөн дүнтэй буюу эерэг үзүүлэлттэй гарчээ. Үүнд:
 - 2021 онд үнэт цаасны зах зээлийн үнэлгээ 95.8 хувиар өсөж 6.0 их наяд төгрөгт хүрч, үнэт цаасны арилжаа 21.6 дахин өссөн;
 - даатгалын компаниудын нийт хөрөнгө 425.4 төгрөгт хүрсэн нь өмнө оноос 43.3 тэрбум төгрөг буюу 11.3 хувиар, даатгалын тохиолдлын улмаас 68.9 тэрбум төгрөгийн нөхөн төлбөр олгосон нь өмнөх оноос 9.1 тэрбум төгрөг буюу 15.2 хувиар тус тус өссөн;
 - Банк бус санхүүгийн салбарт зээлийн жигнэсэн дундаж хүү 2.7 хувь болж өмнөх оноос 0.1 пунктээр, чанаргүй зээлийн нийт зээлд эзлэх үзүүлэлт 7 хувьд хүрч өмнөх оноос 3.3 пунктээр тус тус буурсан;
 - Хадгаламж зээлийн хоршооны салбарт зээлийн жигнэсэн дундаж хүү 2.2 хувь болж өмнөх оноос 0.8 пунктээр, чанаргүй зээлийн нийт зээлд эзлэх үзүүлэлт 3.5 хувьд хүрч өмнөх оноос 0.9 пунктээр тус тус буурсан.
3. Тайлант хугацаанд зохицуулалт үйлчилгээний орлого төвлөрүүлэлт 35.5 хувиар, тэмдэгтийн хураамжийн орлого төвлөрүүлэлт 26.3 хувиар тус тус өссөн үзүүлэлттэй байна;

4. Эрх зүйн орчны хувьд 2021 онд банкны үйл ажиллагаанаас бусад санхүүгийн үйлчилгээг зохицуулах, хянахтай холбогдсон ач холбогдол бүхий хуулиуд батлагдсан байна. Үүнд:
 - Банкны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль;
 - Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, мөнгөн хөрөнгийн шилжүүлэг, зээлийн үйл ажиллагааны тухай хууль;
 - Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн тухай хууль.
5. Санхүүгийн зохицуулах хороо нь 2021 онд нийт 7 журмыг шинээр боловсруулж, батлуулснаас технологид суурилсан санхүүгийн шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээ, бизнес загварыг хязгаарлагдмал хүрээнд бодитоор туршин нэвтрүүлэх “Сэндбокс зохицуулалтын орчны журам”-ыг боловсруулж баталсан нь банкны үйл ажиллагаанаас бусад санхүүгийн зах зээл дэх цахим санхүүгийн хөгжилд бодитой хувь нэмэр болохуйц шийдвэр, үйл ажиллагаа болсон байна;
6. Санхүүгийн зохицуулах хороо нь 2021 онд Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахалтай холбогдуулан хязгаарлалт тогтоосон нөхцөлд үйл ажиллагаа явуулж байсан хэдий ч хяналт тавих чиг үүргийн хүрээнд газар дээрх шалгалтыг 191 удаа зохион байгуулж, давхардсан тоогоор сар, улирлын 10,509 санхүүгийн болон зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийн тайлан, мэдээнд зайны хяналт хийжээ;
7. Ази, номхон далайн мөнгө угаахтай тэмцэх бүлгээс гаргасан “Дахин үнэлгээний тайлан”-д **“хэсэгчлэн биелүүлсэн”** үнэлгээг 1 шатаар ахиулж **“ихэнхийг биелүүлсэн”** үнэлгээ өгсөн буюу Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн хэрэгжилтийг хангах хүрээнд 2021 онд үр дүнтэй ажилласан байна.

Тайлантай холбогдуулан цаашид анхаарч ажиллах хүрээнд:

1. Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.2 дахь хэсэгт “бүрэн эрхийнхээ хүрээнд ... санхүүгийн зах зээлийн тогтвортой байдлыг дэмжих зорилгоор шаардлагатай шалгуур үзүүлэлт, бусад хэм хэмжээ тогтоох” чиг үүргийн хүрээнд хэрэгжүүлсэн арга хэмжээ, үр дүнгийн талаар тодорхой тайлагнан ирүүлэх;
2. Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.7 дахь хэсэгт “Хорооны ажилтны ёс зүйн дүрмийг баталж, биелэлтэд нь хяналт тавих” гэж заасны дагуу ажилтны ёс зүйн дүрмийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах;
3. Санхүүгийн зохицуулах хорооны Хяналтын зөвлөлийг хууль болон холбогдох журамд заасан чиг үүргийн дагуу ажиллуулж, Санхүүгийн зохицуулах хорооны үйл ажиллагаанд тавих хяналтыг сайжруулах;
4. Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 29 дүгээр зүйлд заасны дагуу Хяналтын зөвлөлийг бүрэн бүрэлдэхүүнээр нь ажиллуулахад анхаарах;
5. Банкны үйл ажиллагаанаас бусад санхүүгийн зах зээлийн зохицуулалт, хяналтад хамаарах чиглэлээр Монгол Улсын урт, дунд, богино хугацааны бодлогын баримт бичгүүдийн 2021 оны хэрэгжилтийг ирүүлэхдээ хэт өндөр үнэлгээ өгсөн буюу нийт 4 бодлогын баримт бичгийг 95-98 хувийн биелэлттэй гэж үнэлсэн. Цаашид хяналт шинжилгээ, үнэлгээний аргачлалын дагуу бодитой үнэлж ирүүлэхэд анхаарах;

6. Цаашид Монгол Улсын Их Хурлын Хяналт шалгалтын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1.9 дэх заалтын дагуу тухайн жилийн үйл ажиллагааны тайланг ирүүлэхдээ хуулиар олгосон бүрэн эрх, чиг үүргийн дагуу бүрэн гүйцэд, иж бүрэн, товч тодорхой үр дүнд чиглэсэн байдлаар тайлагнахад тус тус анхаарах шаардлагатай байна.

ХЯНАЛТ ШАЛГАЛТ, ҮНЭЛГЭЭНИЙ ГАЗАР